

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.020

Байгаль орчныг хамгаалах стандартын систем.
Үндсэн дүрэм

MNS 0017-0-0-06:79

Үнэ Стандартын Улсын Хорооны 1979 оны 4-р сарын 12-ны өдрийн 31 тоот тогтоолын дагуу 1979 оны 5-р сарын 1-ний өдрөөс 1984 оны 5-р сарын 1 хүртэл мөрдөнө.

Энэхүү стандарт нь байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглахад чиглэгдсэн стандартын системийг боловсруулж, нэвтрүүлэхэд мөрдөх үндсэн журмыг тогтооно.

1 Ерөнхий зүйл

1.1 Байгаль орчныг хамгаалалын стандартын систем нь байгалийн нөөцийг зохистой ашиглах, байгалийн баялагийг сэргээн хамгаалахад чиглэгдэх харилцан уялдаа бүхий стандартуудын цогцолбороос бүрдэнэ.

1.2 Нийгмийн үйл ажиллгааны дүнд бий болж байгаль, хүний эрүүл мэндэд нөлөөлөх шууд ба шууд бус хорт нөлөөг урьдчилан сэргийлэх, байгалийн нөөцийг зохистой ашиглах, байгалийн баялгийг сэргээн хамгаалах зорилгоор хүний үйл ажиллагаа ба хүрээлэн байгаа байгаль орчин хоорондын зохистой нөлөөллийг тогтооход чиглэгдсэн системтэй арга хэмжээг байгаль орчны хамгаалал гэнэ.

1.3 Байгаль орчны хамгаалалын стандартчилалын үндсэн зорилт нь:

- Байгаль орчны цогцолборыг хамгаалах
- Байгалийн нөөцийг сэргээн зохистой ашиглах
- Үйлдвэрлэлийн хөгжил, хүрээлэн байгаа байгаль орчны хоорондын тэнцвэрийг хангах
- Хүн төрөлхтөний ашиг тусын тулд хүрээлэн байгаа байгаль орчны чанарын удирдлагыг боловсронгуй болгоход оршино.

1.4 Байгаль орчны хамгааллын стандартчилал нь:

- хөрс шороо, гол мөрөн, усан сан болон агаар мандал дахь бохирдуулах бодисыг зөвшөөрсөн дээд хэмжээ /концентраци/ -нээс хэтрүүлэхгүй байлгах, багасгах зорилгоор үйлдвэрлэлийн, тээврийн, хөдөө аж ахуйн болон ахуй хэрэгцээний хаягдал усыг цэвэрлэхгүйгээр хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх явдлыг хязгаарлах.
- Улсын хилийн доторх усан сан, тэдгээрийн усны болон биологийн нөөцийг хамгаалж зохистой ашиглах
 - Үйлдвэрлэл, тээвэр, аж үйлдвэрийн барилга байгууламжийн хэрэгцээнд зориулан газар олгох, хуваарилах зохистой нормативийг мөрдөх газрыг зохистой ашиглах, хамгаалах, газар зохион байгуулах ажлыг журамлах,
 - Биологийн нөөцийг аригтай ашиглах, хамгаалах
 - Ан амьтдын нөхөн үйлдвэрлэлийг хангах, тэдгээрийг оршин суурьших тохиромжтой нөхцөлийг бий болгох,

- Байгалийн дархан цазтай фондыг хамгаалах /дархан цаазтай ан амьтан, газар, ус г.м/
- Газрын доорхи баялагийн ашиглалтыг сайжруулах зэрэг улс ардын аж ахуйн чухал асуудлыг шийдвэрлэхэд туслана.

1.5 Байгаль орчны хамгааллын стандартын системийг экологийн, ариун-цэвэр эрүүл ахуйн, техникийн болон эдийн засгийн шаардлагыг оролцуулан мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу боловсруулна.

2 Стандартын системийн ангилал, объект, бүтэц

2.1 Байгаль орчны хамгааллын стандартын систем нь 1-р хүснэгтэд заасан цогцолбор стандартуудаас бүрдэнэ.

1-р хүснэгт

Байгаль орчны хамгааллын стандартын системийн цогцолбор

Цог-цол-борын шифр	Нэр төрөл	Товчилсон нэр
0.	Байгаль орчны хамгааллын ажлын зохион байгуулалт, арга зүйн стандартын цогцолбор	
1.	Усыг зохистой ашиглах, хамгаалахтай холбогдолтой стандартын цогцолбор	Усан мандал /гидросфера/
2.	Агаар мандлыг бохирдлоос хамгаалахтай холбогдолтой стандартын цогцолбор	Агаар мандал /атмосфера/
3.	Биологийн нөөцийг зохистой ашиглахтай холбогдолтой стандартын цогцолбор	Биологийн нөөц /биологические ресурсы/
4.	Хөрсийг зохистой ашиглаж хамгаалахтай холбогдолтой стандартын цогцолбор	Хөрс шороо /почвы/
5.	Газрын ашиглалтыг сайжруулахтай холбогдсон стандартын цогцолбор	Газар /земли/
6.	Ургамлыг хамгаалахтай холбогдсон стандартын цогцолбор	Ургамлын аймаг /флора/
7.	Ан амьтдыг хамгаалах хүрээн дэхь стандартын цогцолбор	Амьтны аймаг /фауна/
8.	Ландшафтыг боловсруулах, хамгаалахтай холбогдсон стандартын цогцолбор	/ландшафт/
9.	Газрын доорхи баялагийг хамгаалах зохистой ашиглахтай холбогдсон стандартын жагсаалт	Газрын доорхи баялаг /недра/

2.2 Байгаль, орчны хамгааллын стандартын цогцолборын үлгэрчилсэн бүтэц нь дараах стандартчиллын объектоос бүрдэнэ. Үүнд:

- нэр томъёо, тодорхойлолт
- ангилал
- хүрээлэн байгаа байгаль орчинг бохирдуулах бодисын концентрацийн зөвшөөрсөн дээд хэмжээ /концентраци/-ПДК

- элдэв хаягдал дахь бохирдуулагч бодисын зөвшөөрсөн дээд хэмжээг тооцох арга
- байгалийн нөөцийг зохистой ашиглах арга, дүрэм, журам, норм
- хүрээлэн байгаа орчинд нөлөөлөх хорт нөлөөлөлийг зайлуулах, байгалийн нөөцийг ашиглах ажлыг явуулах дүрэм
- хүрээлэн байгаа орчныг бохирдлоос хамгаалах, хяналт тавих төхөөрмж аппарат, барилга байгууламжинд тавих шаардлага
- байгалийн объектүүдийн цогцолбор үйлчилгээг хангаж чадах дэвсгэр нутаг, акваторыг уур амьсгалын янз бүрийн бүсэнд зохион байгуулах дүрэм, журам
- байгалийн объектийн байдал, аж ахуйн үйл ажиллагааны нөлөөллийг хэмжих үзүүлэлтийг тодорхойлох арга г.м болно.

2.3 Стандартчилах объектын төрлийг харгалзан стандартын ангилалын бүлгийг дараах байдлаар тогтооно. /2-р хүснэгт/

2-р хүснэгт

Байгаль орчны хамгаллын
стандартын системийн стандартын ангиллын бүлэг

Бүлгийн шифр	Стандартын бүлгийн нэр
0.	Үндсэн дүрэм
1.	Нэр томъёо тодорхойлолт, ангилал
2.	Байгаль орчны бохирдолт хог хаягдлын нөлөөлөл байгалийн нөөцийн ашиглалтын хэмжээг илэрхийлэх үзүүлэлтүүд
3.	Байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах журам
4.	Аж ахуйн ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн цар хүрээ, байгалийн объектүүдийн бодит байдлын хэмжээг тодорхойлох арга.
5.	Хүрээлэн байгаа орчны бохирдолтод хяналт тавих, хэмжил явуулах хэрэгсэлд тавих шаардлага
6.	Хүрээлэн байгаа орчныг бохирдлоос хамгаалах зориулалттай барилга байгууламж, аппарат хэрэгсэлд тавих шаардлага.
7.	Бусад стандартууд

2.4 Байгаль орчны хамгааллын стандартын тэмдэглэгээ нь стандартын ангилалаар тогтоосон системийн дугаар /17/ цогцолборийн шифр, бүлгийн шифр, стандартын дэс дугаар, стандартыг бүртгэсэн он зэргээс бүрдэнэ.

Жишээ нь: Байгаль орчны хамгааллын үндсэн дүрмийн стандартын тэмдэглэгээ нь:

79 – стандартыг баталсан он

01 – стандартын дэс дугаар

0 - бүлгийн шифр

0 – цогцолборын шифр

17 – системийн дугаар /байгаль хамгааллын стандарт/

MNS - стандартын анги /улсын стандарт/

ТӨГСӨВ.